

# СЭНДБОКСЫН ОРЧНЫ ТОЙМ

2023 оны I улирал

# АГУУЛГА

<b>НЭГ.</b>	<b>ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ТӨЛӨВ</b>	<b>1</b>
<b>ХОЁР.</b>	<b>СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>2</b>
2.1	Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ	3
2.2	P2P зээлийн үйлчилгээ	5
2.3	Хамтын санхүүжилтийн үйлчилгээ	7
2.4	Инсуртекийн үйлчилгээ	8
<b>ГУРАВ.</b>	<b>БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ</b>	<b>9</b>

## **ХОЛБОО БАРИХ**

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР,  
СЭНДБОКСЫН АЛБА

УТАС: 51-261106

И-МЭЙЛ: SANDBOX@FRC.MN

ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН IV БАЙР, БАГА ТОЙРУУ 3,  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, УЛААНБААТАР ХОТ, 15160

## ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ТӨЛӨВ

Технологид суурилсан шинэ, шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгож буй зохицуулалтын арга хэрэгсэл болох “Сэндбоксын зохицуулалт” 2021 оны 3 дугаар сард санхүүгийн зах зээлд нэвтрэн санхүү, технологийн компаниудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ турших боломжийг олгож байна.

2021.03.01–ний өдөр “Сэндбоксын зохицуулалтын орчны журам” батлагдсан.



2022.12.30–ны өдөр Р2Р зээлийн үйлчилгээ, Хамтын санхүүжилтийн үйлчилгээ, Инсуртек үйлчилгээ сэндбоксын орчинд орсон.




2023.04.03–ны өдөр “Сэндбоксын зохицуулалтын орчны журам” шинэчлэн батлагдсан.



2021 оны 9 дүгээр сараас эхлэн Сэндбоксад оролцох хүсэлтийг хүлээн авч эхэлсэн.

2021.09.24–ний өдөр “Сэндбоксын зөвлөлийн дүрэм” батлагдан 2021.10.07–ны өдөр Зөвлөл байгуулагдсан.



2022.12.30–ны өдөр Дижитал бонд сэндбоксын орчноос гарч, Репо хэлцлийн үйлчилгээ нь сэндбоксын туршилтын хугацааг сунгасан.

2021.11.01–ний өдөр Цахим мөнгөнд суурилсан дижитал бонд,

2021.12.27–ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд сэндбоксын зохицуулалтыг тусгасан.



2021.12.17–ны өдөр Репо хэлцлийн платформын үйлчилгээ тус тус сэндбоксын орчинд орсон.

2022.04.20–ны өдөр “Сэндбоксын алба” байгуулагдсан.



## СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

### Сэндбоксоод ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 15 хүсэлт ирсэн бөгөөд эдгээрээс 6 бүтээгдэхүүн, үйлчилгээг Сэндбоксын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 5 бүтээгдэхүүнийг сэндбоксын орчинд оруулсан.



### Сэндбоксын орчинд орсон бүтээгдэхүүн, үйлчилгээ

Нийт 5 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбоксын орчинд орсноос 1 үйлчилгээ 1 жилийн хугацаанд туршигдан сэндбоксоос гарч, 1 үйлчилгээ туршилтын хугацаагаа 1 жилээр сунгаж, 3 үйлчилгээ сэндбоксын орчинд шинээр орж 3 дахь сардаа туршигдаж байна.



ББСБ-уудын репо хэлцлийн зуучлалын платформын үйлчилгээ. 2021.12.17-ны өдөр Сэндбоксын орчинд 1 жилийн хугацаатайгаар орсон бөгөөд 2022.12.30-ны өдөр туршилтын хугацааг 1 жилээр сунгасан.




P2P зээлийн үйлчилгээ. 2022.12.30-ны өдөр Сэндбоксын орчинд орсон.



Лайка платформуор хүргэж буй инсуртек үйлчилгээ. 2022.12.30-ны өдөр Сэндбокс орчинд орсон.



Монпэй дижитал бонд нь 2021.11.01-ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд туршигдаж 2022.12.30-ны өдөр сэндбокс зохицуулалтын орчноос гарсан.



Платформд суурилсан зээл, урамшуулал, хандивын хамтын санхүүжилтийн үйлчилгээ. 2022.12.30-ны өдөр Сэндбокс орчинд орсон.

## Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021.12.17–ны өдөр сэндрокс орчинд орсон бөгөөд 2022 онд Сэндрокс зохицуулалтын орчинд турших хугацааг сунгах хүсэлтийг гаргаж тус хүсэлтийн дагуу 2022.12.30–ны өдрийн 05 дугаар зөвлөмж, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 550 дугаар тушаалаар сэндроксын хугацааг сунган 2 дахь жилдээ туршиж байна.



Тайлант улиралд репо хэлцэлийн үйлчилгээ буюу мөнгөний захын арилжаанд 18 худалдан авагч байгууллага, 16 худалдагч байгууллага оролцсон бөгөөд нийт 149 удаагийн хэлцлээр 30.12 тэрбум төгрөгийн арилжаа хийгджээ. Мөн 1 сараас 3 сард зээлдэгч, зээлдүүлэгчийн тоо болон арилжааны тоо, дүн нь огцом нэмэгдсэн бөгөөд энэ улиралд мөнгөний зах нь 20 удаагийн 6.9 тэрбум төгрөгийн илүүдэл нийлүүлэлт, 2 удаагийн 700.0 сая төгрөгийн илүүдэл эрэлттэй байсан.



Репо зээлийн дундаж хугацаа

**31** хоног



Репо зээлийн дундаж хүү

**17.3%**


Мөнгөний захын арилжаанд нэг, хоёр, дөрөв, арван хоёр долоо хоногийн хугацаатай репо хэлцэл хийгддэг бөгөөд тайлант хугацаанд хийгдсэн репо зээлийн дундаж хугацаа 31 хоног байна. Мөн репо хэлцлийн зах зээл дээр хийгдэж буй зээлийн жигнэсэн дундаж хүү 17.3 хувьтай байна. 2023 оны эхний гурван сарын мөнгөний зах зээлийн ерөнхий төлөв байдлыг илэрхийлэх статистик үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харууллаа.

Мөнгөний захын ерөнхий үзүүлэлтүүд

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
1 сар	7	8	30	6,960,000,000	16.83	27
2 сар	16	13	68	12,330,000,000	17.42	39
3 сар	12	14	56	10,830,000,000	17.27	28
<b>Нийт</b>	–	–	<b>149</b>	<b>30,120,000,000</b>	<b>17.34</b>	<b>31</b>

Мөнгөний захын хүүгийн түвшин болон арилжааны дүнг зурагт харуулав. Мөнгөний захын арилжааг бүтээгдэхүүнээр нь ангилан харвал 1 ба 12 долоо хоногийн хугацаатай репо зээлийн хэлцэл маш бага хийгддэг бол мөнгөний захын хамгийн эрэлттэй бүтээгдэхүүн нь 2 болон 4 долоо хоногийн хугацаатай репо зээл байна. Мөн улирал бүрийн 1 дүгээр сард биелсэн хэлцлийн тоо бага байдаг бол 2 болон 3 дугаар сард өссөн хандлага ажиглагдаж байна. Үүнээс харахад хэрэглэгчдийн зан төлөв, баяр ёслолоос хамаарсан улирлын нөлөө нь мөнгөний захын арилжааны тоо болон дүнд нөлөөлж байна. Харин мөнгөний захын хүүгийн түвшнийг өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 0.7 пунтээр буурч 17.3 хувьд хүрсэн.

Мөнгөний захын арилжааны дүн, репо зээлийн хугацаагаар, тухайн сараар




Мөнгөний захын хүүгийн түвшин ба арилжааны дүн, тухайн улирлаар



## P2P зээлийн үйлчилгээ

P2P зээлийн үйлчилгээ нь 2022.12.30-ны өдөр Сэндбоксын орчинд орсон бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээ юм.



**96.2%**  
зээлдэгч



**3.8%**  
хөрөнгө оруулагч

P2P зээлийн үйлчилгээ нь 2023 оны 2 дугаар сараас эхлэн зах зээлд нэвтэрч эхэлсэн бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар тус платформоор нийт 208 харилцагч P2P зээлийн үйлчилгээг хүртсэн байна. Эдгээр харилцагчдын 3.8 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 96.2 хувь нь зээлдэгч байна.

Платформоор нийт 62.8 сая төгрөгийн зээл олгогдсон бөгөөд зээлийн багцыг 100 хувь хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлж байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.0 хувь байгаа бөгөөд олгосон зээлийн багцыг зөвхөн 1-3 сар хүртэлх хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 88.1 хувийг 1 жилийн хугацаатай хөрөнгө оруулалт, 11.9 хувийг хагас жил буюу 6 сарын хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.




**3 сарын хугацаатай**



**Хэвийн**  
**97.6%**



**Хугацаа хэтэрсэн**  
**2.4%**



**Чанаргүй**  
**0.0%**

P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 97.6 хувийг хэвийн зээл, 2.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл бүрдүүлж байна.

эмэгтэй



60.1%

эрэгтэй



39.9%

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 60.1 хувь нь эмэгтэй, 39.9 хувь нь эрэгтэй байна. Харин нийт харилцагчдын 59.1 хувийг 18–35 насныхан, 29.3 хувийг 36–45 насныхан, 10.1 хувийг 46–55 насныхан, 1.5 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Мөн харилцагчдын боловсролын түвшний хувьд 68.7 хувь нь дээд, 2.9 хувь нь тусгай дунд, 23.6 хувь нь бүрэн дунд, 4.3 хувь нь дунд, 0.5 хувь нь бага боловсролтой харилцагчид байна.

Насны бүлгээр

18–35 нас



59.1%

36–45 нас



29.3%

46–55 нас



10.1%

55–аас дээш



1.5%

Боловсролын түвшингээр



Дээд

Тусгай  
дундБүрэн  
дунд

Дунд

Бага

68.7%

2.9%

23.6%

4.3%

0.5%

## Хамтын санхүүжилтийн үйлчилгээ

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь 2022.12.30–ны өдрөөс эхлэн сэндрбоксын орчинд орсон ба одоогоор урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг туршиж байгаа бол зээл, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэхээр ажиллаж байна.



Тус үйлчилгээ нь 2023 оны 2 дугаар сараас эхлэн зах зээлд нэвтэрсэн ба 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн 3 төсөлд 88 хөрөнгө оруулагчаас нийт 27.5 сая төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлээд байна. Платформоор дамжуулан санхүүжилт босгосон эдгээр 3 төсөл нь бүгд 1 сараас бага хугацаатай урамшуулалт санхүүжилтийн төслүүд юм.

Тайлант хугацаанд хүүхдийн сэтгэл зүй, бие бялдрын зөвлөгөө сургалт өгөх “Намайг хараач зорилтот төсөл”, рэгги пянзны урьдчилсан захиалга, “Stay yoga” иогийн хямдруулсан сургалтууд тус платформоор дамжуулан урамшуулалт хамтын санхүүжилтийг дунджаар 72 хувийн биелэлттэйгээр босгосон. Мөн тухайн платформд нийтлэгдсэн урамшуулалт санхүүжилтийн санхүүжилт босгох дундаж хугацаа 8 хоног байна.



Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 27.5 хувь нь 18–35 нас, 57.5 хувь нь 36–45 нас, 13.7 хувь нь 46–55 нас, 1.3 хувь нь 55–аас дээш насны хөрөнгө оруулагчид байна

### Хөрөнгө оруулагчид насны бүлгээр

**18–35 нас**



**27.5%**

**36–45 нас**



**57.5%**

**46–55 нас**



**13.7%**

**55–аас дээш**



**1.3%**

## Инсуртекийн үйлчилгээ

Инсуртекийн үйлчилгээ нь 2022.12.30-ны өдөр сэндбоксын орчинд орсон ба тус үйлчилгээ нь хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлд суурилсан газрын зураглалыг хөгжүүлж, даатгалын эрсдэлийг үнэлэх давуу талтай.



Инсуртекийн үйлчилгээний платформд бүртгэлтэй харилцагчдын тоо 1219-д хүрсэн бөгөөд тус платформ нь смарт төхөөрөмж, жолоочийн хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн ослын нийт 5 хэлбэр, 14 төрлийн даатгалын үйлчилгээг 9 даатгуулагчид хүргэсэн байна.

Эдгээр даатгалын бүтээгдэхүүнүүд нь нийт 27 сая төгрөгийн үнэлгээтэй бөгөөд нийт хураамжийн орлогын 23.5 хувийг смарт төхөөрөмжийн даатгал, 41.2 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 35.3 хувийг эрүүл мэндийн даатгал тус тус бүрдүүлж байна. Мөн тайлант хугацаанд 1 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг 2 даатгуулагчид олгосон байна.

### Смарт төхөөрөмжийн даатгал



23.5%

### Жолоочийн хариуцлагын даатгал



41.2%


### Эрүүл мэндийн даатгал



35.3%

## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

### Хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд





Сэндбокс зохицуулалтын орчин нь зах зээлд нэвтрээд удаагүй хэдий ч технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний салбар хурдацтай хөгжиж буй тул салбарын шинэчлэлтэд нийцсэн өөрчлөлтийг тус зохицуулалтын орчинд хийх зайлшгүй шаардлага үүсэн “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэн боловсруулж батлууллаа. Мөн шинэчлэн батлагдсан журмыг нөлөөллийн шинжилгээ, холбогдох судалгааны хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Сэндбокс орчинд хүсэлт гаргах сонирхолтой компаниудад зориулан “Сэндбокс зохицуулалтын орчны гарын авлага”-ыг боловсруулж олон нийтэд хүргэсэн.

### Хурал, семинар, уулзалт, хяналтын хүрээнд

Сэндбокс орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 5 компанитай 7 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг гүйцэтгэн ажиллаж байна.

Финтекийн хөгжил болон зохицуулалтын орчны талаарх цахим болон танхимын сургалт, уулзалтуудад тогтмол оролцож байна.



Сэндбоксад туршигдаж буй 4 бүтээгдэхүүн тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягтыг боловсруулан 7 хоног, сарын мэдээ, улирлын тайланг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

### Сэндбоксын орчныг олон нийтэд таниулах ажлын хүрээнд



“Сэндбокс зохицуулалтын орчин гэж юу вэ?”, “Сэндбоксын орчинд хүсэлт хэрхэн гаргах вэ?”, “Сэндбокс зохицуулалт олон улсад”, “Сэндбокс зохицуулалтын орчны хөгжил” сэдэвт зурагт хуудаснуудыг боловсруулан олон нийтэд түгээсэн. Мөн СЗХ-оос сар бүр эрхлэн гаргадаг “Хүртээмжтэй санхүү сэтгүүл”-ийн 1 дүгээр сарын дугаарыг сэндбокс зохицуулалт гэсэн сэдэвтэйгээр боловсруулж, олон нийтэд түгээлээ.

